



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Сайнцагаан сумын ерөнхий боловсролын Мандал сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДУА-2026/110/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Дундговь аймаг 2026 он</p>	<p>Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох Утас: 70592439 Цахим хаяг: <a href="mailto:Munkhtogtokhr@audit.gov.mn">Munkhtogtokhr@audit.gov.mn</a></p> <p>Аудитын менежер: Т.Батсайхан Утас: 70592225 Цахим хаяг: <a href="mailto:Batsaikhant@audit.gov.mn">Batsaikhant@audit.gov.mn</a></p> <p>Аудитыг гүйцэтгэсэн: Azure Хүлүг Аудит ХХК Утас: 70110090 Цахим хаяг: <a href="mailto:audit@azure.mn">audit@azure.mn</a></p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	7
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	8
3.1 Төлбөрийн акт .....	8
3.2 Албан шаардлага .....	8
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	10

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум  
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,  
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

**ДУНДГОВЬ АЙМГИЙН САЙНЦАГААН  
СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН  
МАНДАЛ СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ  
М.ЭНХБАЯР ТАНАА**

2026.02.13

№

26

танай

-ны №

-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дундговь аймгийн Сайнцагаан сумын ерөнхий боловсролын Мандал сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Сайнцагаан сумын ерөнхий боловсролын Мандал сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад Монгол улсын Засгийн газрын шийдвэрээр 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс төрийн албан хаагчийн үндсэн цалинг нэмсэнтэй холбоотой цалингийн зардал өмнөх оноос 466,802.7 мянган төгрөгөөр өссөн байна. Мөн балансаас балансанд хөрөнгө шилжүүлсэн авсантай холбоотой үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 273,990.4 төгрөгөөр өсжээ. Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

**Аудитын гол асуудал**

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал байхгүй.

**Бусад асуудлын хэсэг**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

4826050087

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 69 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг 95.6 хувийн гүйцэтгэлтэй гэж дүгнэсэн байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Р.МӨНХТОГТОХ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>400,450,361.92</b>	<b>402,566,192.08</b>
31200	Банканд байгаа бэлэн мөнгө	400,450,361.92	402,566,192.08
31210	Төгрөг	400,450,361.92	402,566,192.08
31211	Төрийн сангийн харилцах	380,094,144.40	402,566,192.08
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	20,356,217.52	-
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>40,852,223.93</b>	<b>17,748,816.82</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	999,962.00	1,265,400.00
33101	Цалингийн авлага	654,516.00	1,265,400.00
33103	ХАОАТ-ын авлага	345,446.00	-
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	16,483,367.52
33500	Бусад авлага	39,852,261.93	49.30
33510	Байгууллагаас авах авлага	39,803,292.64	49.30
33520	Хувь хүмүүсээс авах авлага	48,969.29	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>290,230,129.06</b>	<b>303,657,445.05</b>
35100	Түүхий эд материал	163,934,144.24	147,864,270.60
35110	Тусгай зориулалттай материал	163,394,354.24	147,787,120.60
35130	Эм боох материал	539,790.00	77,150.00
35400	Хангамжийн материал	126,295,984.82	155,793,174.45
35410	Бичиг хэргийн материал	838,500.00	3,956,600.00
35420	Аж ахуйн материал	114,792,572.82	150,019,870.45
35440	Түлш, шатах тослох материал	507,000.00	-
35450	Барилгын засварын материал	8,536,100.00	1,644,800.00
35460	Хүнсний материал	1,621,812.00	171,904.00
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)</b>	<b>731,532,714.91</b>	<b>723,972,453.95</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>3,652,481,028.78</b>	<b>3,926,471,463.20</b>
39200	Биет хөрөнгө	3,472,481,028.78	3,744,941,063.20
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,298,882,848.44	3,480,897,364.54
39202	Хуримтлагдсан элэгдэл - Барилга	(408,678,923.75)	(445,746,289.53)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	82,390,495.00	82,390,495.00
39204	Хуримтлагдсан элэгдэл - Тээврийн хэрэгсэл	(44,484,247.80)	(59,312,330.40)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	715,103,304.60	758,973,395.70
39206	Хуримтлагдсан элэгдэл - Тоног төхөөрөмж	(291,663,680.06)	(288,116,377.35)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	271,251,998.88	243,182,379.68
39208	Хуримтлагдсан элэгдэл - Тавилга	(187,587,912.11)	(64,594,720.02)
39217	Номын фонд	37,267,145.58	37,267,145.58
39300	Биет бус хөрөнгө	180,000,000.00	181,530,400.00
39301	Програм хангамж	3,829,670.00	1,530,400.00
39302	Хуримтлагдсан элэгдэл - Программ хангамж	(3,829,670.00)	-
39303	Бусад биет бус хөрөнгө	180,000,000.00	180,000,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)</b>	<b>3,652,481,028.78</b>	<b>3,926,471,463.20</b>
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)</b>	<b>4,384,013,743.69</b>	<b>4,650,443,917.15</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>158,852,534.58</b>	<b>107,660,103.58</b>
41300	Өглөг	158,852,534.58	107,660,103.58
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	790,681.00	913,178.00
41311	Цалингийн өглөг	790,681.00	913,178.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	60,511,928.00	-
413203	Түлш халаалтын өглөг	54,200,602.00	-
413204	Цэвэр, бохир усны өглөг	6,311,326.00	-
41360	Бусад өглөг	97,549,925.58	106,746,925.58
41361	Байгууллагад төлөх өглөг	97,549,925.58	106,746,925.58
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР (IV)</b>	<b>158,852,534.58</b>	<b>107,660,103.58</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>4,225,161,209.11</b>	<b>4,542,783,813.57</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	180,000,000.00	180,000,000.00
511001	Засгийн газрын оруулсан капитал засгийн газрын сан	180,000,000.00	180,000,000.00
51200	Хуримтлагдсан үр дүн	4,045,161,209.11	4,362,783,813.57

51210	Өмнөх үеийн үр дүн	3,722,737,149.30	4,045,161,209.11
51220	Тайлант үеийн үр дүн	322,424,059.81	317,622,604.46
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)</b>	<b>4,225,161,209.11</b>	<b>4,542,783,813.57</b>
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V)</b>	<b>4,384,013,743.69</b>	<b>4,650,443,917.15</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/			
Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>13</b>	<b>ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>3,481,661,000.00</b>	<b>3,953,174,600.00</b>
1310	Улсын төсвөөс	3,031,236,200.00	3,318,116,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,031,236,200.00	3,318,116,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	450,424,800.00	635,058,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	450,424,800.00	635,058,400.00
<b>12</b>	<b>БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО</b>	<b>297,585,907.73</b>	<b>653,431,450.92</b>
1200	Нийтлэг татварын бус орлого	297,585,907.73	653,431,450.92
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	121,082,438.00	127,373,240.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлого	62,002,700.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	59,079,738.00	127,373,240.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	91,937,590.00	460,988,110.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Материал	84,565,879.73	65,070,100.92
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>3,779,246,907.73</b>	<b>4,606,606,050.92</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,456,898,787.04</b>	<b>4,284,705,488.74</b>
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,419,948,291.77	4,203,383,361.69
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	2,085,810,390.00	2,552,613,121.66
210101	Үндсэн цалин	1,389,950,265.00	1,583,844,141.89
210102	Нэмэгдэл	596,941,516.00	725,496,024.00
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	-	95,335,592.00
210104	Урамшуулал	98,918,609.00	147,937,363.77
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	254,150,611.00	309,453,624.89
210201	Тэтгэврийн даатгал	172,753,212.03	210,063,291.80
210202	Тэтгэмжийн даатгал	20,771,898.71	25,411,765.63
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,323,714.97	12,586,439.42
210204	Ажилгүйдлийн даатгал	9,976,256.48	12,236,557.32
210205	Эрүүл мэндийн даатгал	40,325,528.81	49,155,570.72
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	444,736,120.73	453,500,344.95
210301	Гэрэл, цахилгаан	25,438,301.73	36,406,421.44
210302	Түлш, халаалт	385,424,795.00	385,424,555.00
210303	Цэвэр, бохир ус	33,873,024.00	31,669,368.51
2104	Хангамж, бараа материалын зардал	35,281,060.30	84,300,708.83
210401	Бичиг хэрэг	17,471,980.00	22,376,834.00
210402	Тээвэр, шатахуун	4,846,190.30	7,391,590.10
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,416,690.00	30,113,259.00
210408	Бараа материал акталсны зардал	546,200.00	24,419,025.73
2105	Нормативт зардал	216,914,013.70	271,024,017.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,582,660.00	3,034,950.00
210502	Хоол, хүнс	215,331,353.70	267,989,067.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,082,710.00	70,423,300.00
210604	Урсгал засвар	15,082,710.00	70,423,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	38,115,716.68	46,567,316.30
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	38,115,716.68	46,567,316.30
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	329,857,669.36	415,500,928.06
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	86,635,999.96	140,681,610.20
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол	243,221,669.40	274,819,317.86
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	36,950,495.27	81,322,127.05
2132	Бусад урсгал шилжүүлэг	36,944,500.00	26,710,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	36,944,500.00	26,710,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	5,995.27	54,612,127.05

213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,995.27	54,612,127.05
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)</b>	<b>3,456,898,787.04</b>	<b>4,284,705,488.74</b>
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)</b>	<b>322,348,120.69</b>	<b>321,900,562.18</b>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	-	4,277,957.72
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	4,277,957.72
<b>5</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>-</b>	<b>4,277,957.72</b>
<b>6</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V)</b>	<b>322,348,120.69</b>	<b>317,622,604.46</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>13</b>	<b>ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>3,481,661,000.00</b>	<b>3,953,174,600.00</b>
1310	Улсын төсвөөс	3,031,236,200.00	3,318,116,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,031,236,200.00	3,318,116,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	450,424,800.00	635,058,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	450,424,800.00	635,058,400.00
<b>12</b>	<b>БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО</b>	<b>121,082,438.00</b>	<b>127,505,452.63</b>
1200	Нийтлэг татварын бус орлого	121,082,438.00	127,505,452.63
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	121,082,438.00	127,505,452.63
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлого	62,002,700.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	59,079,738.00	127,505,452.63
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>3,602,743,438.00</b>	<b>4,080,680,052.63</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,326,134,255.94</b>	<b>4,012,924,622.47</b>
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,141,340,351.97	3,731,720,064.90
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	2,085,959,418.00	2,552,279,062.66
210101	Үндсэн цалин	1,390,099,293.00	1,583,844,141.89
210102	Нэмэгдэл	596,941,516.00	725,496,024.00
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	-	95,335,592.00
210104	Урамшуулал	98,918,609.00	147,603,304.77
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	254,793,770.84	309,453,624.89
210201	Тэтгэврийн даатгал	173,396,371.87	210,063,291.80
210202	Тэтгэмжийн даатгал	20,771,898.71	25,411,765.63
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,323,714.97	12,586,439.42
210204	Ажилгүйдлийн даатгал	9,976,256.48	12,236,557.32
210205	Эрүүл мэндийн даатгал	40,325,528.81	49,155,570.72
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	438,424,794.73	514,012,272.95
210301	Гэрэл, цахилгаан	25,438,301.73	36,406,421.44
210302	Түлш, халаалт	385,424,795.00	439,625,157.00
210303	Цэвэр, бохир ус	27,561,698.00	37,980,694.51
2105	Нормативт зардал	28,870,703.00	14,324,776.00
210502	Хоол, хүнс	28,870,703.00	14,324,776.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,494,010.00	70,934,000.00
210604	Урсгал засвар	16,494,010.00	70,934,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	60,580,791.10	48,680,516.30
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	60,580,791.10	48,680,516.30
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	256,216,864.30	222,035,812.10
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	233,481,764.30	202,738,812.10
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	22,735,100.00	19,297,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	184,793,903.97	281,204,557.57
2132	Бусад урсгал шилжүүлэг	184,787,908.70	210,109,063.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	147,843,408.70	183,399,063.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	36,944,500.00	26,710,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	5,995.27	54,612,127.05
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,995.27	54,612,127.05
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	16,483,367.52
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	16,483,367.52

2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (II)</b>	<b>3,326,134,255.94</b>	<b>4,012,924,622.47</b>
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III-I-II)</b>	<b>276,609,182.06</b>	<b>67,755,430.16</b>
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	<b>65,639,600.00</b>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	-	65,639,600.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	65,639,600.00
5	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	-	<b>65,639,600.00</b>
6	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI=IV-V)</b>	-	<b>(65,639,600.00)</b>
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII=III+VI+VII)</b>	<b>276,609,182.06</b>	<b>2,115,830.16</b>
14	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>123,841,179.86</b>	<b>400,450,361.92</b>
15	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>400,450,361.92</b>	<b>402,566,192.08</b>

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн хөрөнгө оруулсан капитал	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>180,000,000.00</b>	<b>3,722,737,149.30</b>	<b>3,902,737,149.30</b>
Тайлант үеийн үр дүн	-	322,348,120.69	322,348,120.69
<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>180,000,000.00</b>	<b>4,045,161,209.11</b>	<b>4,225,161,209.11</b>
Тайлант үеийн үр дүн	-	317,622,604.46	317,622,604.46
<b>2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>180,000,000.00</b>	<b>4,362,783,813.57</b>	<b>4,542,783,813.57</b>

#### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
<b>Татаас, санхүүжилтийн орлого</b>	<b>4,490,271,100.00</b>	<b>4,080,680,052.63</b>	<b>409,591,047.37</b>
Улсын төсвөөс	3,665,929,500.00	3,318,116,200.00	347,813,300.00
Орон нутгийн төсвөөс	635,058,400.00	635,058,400.00	-
Тусламжийн орлого	189,283,200.00	127,505,452.63	61,777,747.37
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>4,490,271,100.00</b>	<b>4,080,680,052.63</b>	<b>409,591,047.37</b>
<b>Ажиллагчидтай холбогдсон зардал</b>	<b>3,169,436,600.00</b>	<b>2,861,732,687.56</b>	<b>307,703,912.44</b>
<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>2,815,810,700.00</b>	<b>2,552,279,062.66</b>	<b>263,531,637.34</b>
Цалин	1,687,280,300.00	1,583,844,141.89	103,436,158.11
Цалингийн тусгай нэмэгдлүүд	1,128,530,400.00	968,434,920.77	160,095,479.23
<b>Нийгмийн хамгааллын шимтгэл</b>	<b>353,625,900.00</b>	<b>309,453,624.90</b>	<b>44,172,275.10</b>
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	268,755,700.00	235,475,057.44	33,280,642.56
Эрүүл мэндийн даатгалын хураамж	84,870,200.00	73,978,567.46	10,891,632.54
<b>Бараа, үйлчилгээний урсгал зардал</b>	<b>1,294,124,500.00</b>	<b>1,104,125,717.39</b>	<b>189,998,782.61</b>
Тогтмол зардал	568,624,400.00	514,012,272.95	54,612,127.05
Гэрэл цахилгааны зардал	39,000,000.00	36,406,421.44	2,593,578.56
Түлш, халаалтын зардал	489,224,400.00	439,625,157.00	49,599,243.00
Цэвэр, бохир усны зардал	40,400,000.00	37,980,694.51	2,419,305.49
Хоол	260,079,300.00	197,723,839.00	62,355,461.00
Бусад бараа үйлчилгээний зардал	311,192,400.00	253,478,089.14	57,714,310.86
Шуудан холбооны зардал	63,997,400.00	48,680,516.30	15,316,883.70
Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	19,297,000.00	19,297,000.00	-
Урсгал засварын зардал	70,934,000.00	70,934,000.00	-
Хөтөлбөр арга хэмжээний зардал	<b>26,710,000.00</b>	<b>92,349,600.00</b>	<b>(65,639,600.00)</b>
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	26,710,000.00	26,710,000.00	-

Биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардал	-	65,639,600.00	(65,639,600.00)
<b>НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН</b>	<b>4,490,271,100.00</b>	<b>4,058,208,004.95</b>	<b>432,063,095.05</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	380,084,144.40	380,084,144.40
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	402,566,192.08	402,566,192.08

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 178,140.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 65,639.6 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 899.7 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 111,601.6 мянган төгрөгийн 2 албан шаардлага тус тус хүргүүлээ.

#### Залруулсан алдаа:

Аудитаар нийт 65,639.6 мянган төгрөгийн 1 алдаа<sup>1</sup> илрүүлж аудитын явцад бүрэн залруулсан. Үүнд:

- Мөнгөн гүйлгээний тайланд биет болон биет бус хөрөнгө худалдан авсан зардлыг 65,639.6 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан.

#### 3.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт 1: Тайлант хугацаанд томилолтоор ажилласан болон чөлөөтэй ажилчдын хоолны хөнгөлөлтийг илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т (*төсвийн үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах*), 16 дугаар зүйлийн 16.5.2-т (*батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийг хөрөнгийг удирдах зарцуулалтад хяналт тавих*), Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т (*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*), 13.6-т (*Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна*) гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хоолны хөнгөлөлтийг илүү олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

Илрүүлэлт 2: Цалингүй чөлөө авсан 2 ажилтны 11 дүгээр сарын цалинг илүү тооцож олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т (*төсвийн үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах*), 16 дугаар зүйлийн 16.5.2-т (*батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийг хөрөнгийг удирдах зарцуулалтад хяналт тавих*), Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т (*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*), 13.6-т (*Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна*), 19 дүгээр зүйлийн 19.1-т (*Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно*) заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Цалинг илүү тооцож олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

#### 3.2 Албан шаардлага

Илрүүлэлт 1: Хөлсөөр ажиллах гэрээний шилжүүлсэн төлбөрт ногдох нийгмийн даатгалын шимтгэлийг суутгаж тайлагнаагүй байна.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Энэ нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-т (*Даатгуулагч, ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл ногдох орлогын бүрэлдэхүүнд дараах цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг хамааруулна*), 19.1.2-т (*Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээ болон тэдгээртэй адилтгах гэрээгээр тохирсон цалин хөлс*), Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн А/262 дугаар тушаалаар батлагдсан "Төрөлжсөн сургалт зохион байгуулах журам"-н 4.7.1-д (*төрөлжсөн сургалтын хичээл зохион байгуулж буй багш, анги удирдсан багш, захирал, сургалтын менежер, бусад ажилтны нэмэгдэл хөлс, түүнд ногдох нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлд 50 хувьтай тэнцэх хэмжээгээр*) гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нийгмийн даатгалын шимтгэлийг суутгаж тайлагнаагүй зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

Илрүүлэлт 2: Тайлант хугацаанд Мэксим консалтинг ХХК, Мобинет ХХК-ийн өр төлбөрийг гэрээнд заасан хугацаанд хуваарийн дагуу төлөөгүй, Санко маркетинг монголиа ХХК-аас хувилах төхөөрөмж худалдан авч өр үүсгэж, хууль тогтоомжтой нийцээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т (*төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх*), 16 дугаар зүйлийн 16.5.1-т (*төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах*), Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т (*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*) гэж заасныг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг хянан удирдах, өр төлбөргүй ажиллаж, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн 63.2 хувийг залруулагдаагүй, 36.8 хувийг залруулсан алдаа эзэлж байна. Нийт 112,501.3 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь 106,269.9 мянган төгрөгийн нийцлийн аудитын зөрчил, 6,231.4 мянган төгрөгийн санхүүгийн тайлангийн аудитын зөрчил байна. Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдах боломжгүй, аудитын дүгнэлтэд нөлөөлөх 6,231.4 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг түвшнээс 36,615.6 мянган төгрөгөөр бага байгаа тул “ӨӨРЧЛӨЛТГҮЙ” дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл :

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Мөнгөн гүйлгээний тайланд биет болон биет бус хөрөнгө худалдан авсан дутуу тайлагнасан.	1	65,639.6	-	-	1	65,639.6	1	65,639.6	-	-
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>65,639.6</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>65,639.6</b>	<b>1</b>	<b>65,639.6</b>	<b>-</b>	<b>-</b>

##### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл :

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант хугацаанд томилолтоор ажилласан болон чөлөөтэй ажилчдын хоолны хөнгөлөлтийг илүү олгосон байна.	1	405.0	1	405.0	-	-	-	-	-	-
Цалингүй чөлөө авсан 2 ажилтны 11 дүгээр сарын цалинг илүү тооцож олгосон байна.	1	494.7	1	494.7	-	-	-	-	-	-
Хөлсөөр ажиллах гэрээний шилжүүлсэн төлбөрт ногдох нийгмийн даатгалын шимтгэлийг суутгаж тайлагнаагүй байна.	1	5,331.7	-	-	1	5,331.7	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>6,231.4</b>	<b>2</b>	<b>899.7</b>	<b>1</b>	<b>5,331.7</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

##### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал:

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант хугацаанд Мэксим консалтинг ХХК, Мобинет ХХК-ийн өр төлбөрийг гэрээнд заасан хугацаанд хуваарийн дагуу төлөөгүй, Санко маркетинг монголиа ХХК-аас хувилах төхөөрөмж худалдан авч өр үүсгэж, хууль тогтоомжтой нийцээгүй байна.	1	106,269.9	-	-	1	106,269.9	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>106,269.9</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>106,269.9</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>